

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/006/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 8/54  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 70704 (Цагдаа), 70711 (Шүүгч болон гэрч, хохирогчийг хамгаалах) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 9,015,085.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 98,000.0 мянган төгрөгийг оруулж, 8,860,484.9 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, зардлын хэмнэлтийн 252,600.7 мянган төгрөгийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050182

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

Байгууллагын даргын 2025 оны А/51 дүгээр тушаалаар “Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалт”-ыг төлбөртэй зохион байгуулж, тайлант онд 30,898.5 мянган төгрөгийн орлого оруулсныг сургалтын үйл ажиллагаанд зарцуулж, сургалтад нийт 60 иргэн хамрагдсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газар нь 2025 онд 7 зорилт 68 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг хэрэгжүүлж, ЦЕГ-ын Стратеги бодлого инновац хөгжлийн албанаас төлөвлөгөөний хэрэгжилтийг 89.0 хувьтай дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



Хоёр: Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>281,416,627.83</b>	<b>321,486,950.63</b>
МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	32,013,340.00	0
Банкинд байгаа бэлэн мөнгө	32,013,340.00	0
Төгрөг	32,013,340.00	0
Төрийн сангийн харилцах	32,013,340.00	0
<b>АВЛАГА</b>	<b>437,627.00</b>	<b>59,647,105.50</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	383,627.00	1,696,729.50
Төлбөртэй үйлчилгээний авлага	54,000.00	54,000.00
Татаас, санхүүжилтийн авлага		57,896,376.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>248,965,660.83</b>	<b>261,839,845.13</b>
Түүхий эд материал	152,501,652.47	135,924,980.47
Тусгай зориулалттай материал	147,240,902.47	134,142,685.47
Эм боох материал	5,260,750.00	1,782,295.00
Хангамжийн материал	47,701,398.36	72,847,494.66
Бичиг хэргийн материал	3,145,982.00	3,920,709.70
Аж ахуйн материал	222,500.00	0
Сэлбэг хэрэгсэл	154,500.00	0
Түлш, шатах тослох материал	4,500,279.67	20,902,948.27
Барилгын засварын материал	1,794,500.00	1,648,000.00
Бусад хангамжийн материал	37,883,636.69	46,375,836.69
Мал амьтад	48,762,610.00	53,067,370.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,555,134,500.17</b>	<b>6,185,339,224.49</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,555,134,500.17</b>	<b>6,185,339,224.49</b>
Биет хөрөнгө	5,180,804,833.50	5,801,529,557.78
Барилга, байгууламж, орон сууц	5,175,510,881.05	5,595,515,022.87
Хуримтлагдсан элэгдэл /Барилга, байгууламж, орон сууц	-634,446,180.30	-783,104,052.28
Авто-тээврийн хэрэгсэл	855,863,026.97	1,293,430,360.19
Хуримтлагдсан элэгдэл/Авто-тээврийн хэрэгсэл	-561,377,809.19	-718,253,824.17
Машин тоног төхөөрөмж (компьютер)	872,922,966.98	1,054,572,916.98
Хуримтлагдсан элэгдэл	-577,076,316.39	-684,171,321.95
Тавилга, аж ахуйн эд хогшил	91,942,098.47	91,942,098.47
Хуримтлагдсан элэгдэл	-73,285,902.74	-77,927,666.30
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	28,944,656.00	28,944,656.00
Бусад үндсэн хөрөнгө	17,305,522.84	17,305,522.84
Хуримтлагдсан элэгдэл	-15,498,110.19	-16,724,154.87
Биет бус хөрөнгө	374,329,666.67	383,809,666.71
Програм хангамж	1,825,000.00	1,825,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-743,333.33	-963,333.29
Газар эзэмших эрх	373,248,000.00	382,948,000.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,836,551,128.00</b>	<b>6,506,826,175.12</b>
ӨР ТӨЛБӨР	2,722,472.59	5,839,052.16
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,722,472.59	5,839,052.16
Өглөг	2,722,472.59	5,839,052.16
Ажилчидтай холбогдсон өглөг	2,622,697.59	254,079.16
Бараа үйлчилгээний зардлын өглөг	96,000.00	0
Бусад өглөг	3,775.00	5,584,973.00
Байгууллагад төлөх өглөг	3,775.00	4,022,523.00
Хувь хүмүүст төлөх өглөг		1,562,450.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧ</b>	<b>5,833,828,655.41</b>	<b>6,500,987,122.96</b>
Засгийн газрын хувь оролцоо	5,833,828,655.41	6,500,987,122.96
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,085,778,623.99	1,085,778,623.99
- төрийн	1,085,778,623.99	1,085,778,623.99
Хуримтлагдсан үр дүн	4,297,787,519.59	4,964,945,987.14
Тайлант үеийн үр дүн		665,850,869.65
Өмнөх үеийн үр дүн	4,297,787,519.59	4,299,095,117.49
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	450,262,511.83	450,262,511.83
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,836,551,128.00</b>	<b>6,506,826,175.12</b>

## 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>9,014,704,853.03</b>	<b>10,292,015,752.84</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,182,589,853.03	1,228,486,552.84
Нийтлэг татварын бус орлого	2,182,589,853.03	1,228,486,552.84
Төсөв байгууллагын өөрийн орлого	149,544,754.50	151,356,146.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	148,831,755.00	151,356,146.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	188,000.00	
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	2,020,500,368.22	1,035,421,425.04
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	13,069,729.81	41,708,981.80
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,832,115,000.00	9,063,529,200.00
Улсын төвлөрсөн төсвөөс	6,711,750,000.00	9,015,085,700.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,711,755,000.00	9,015,085,700.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	120,360,000.00	48,443,500.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,500,000.00	2,500,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,104,000.00	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,756,000.00	45,943,500.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>7,297,155,470.56</b>	<b>9,624,983,633.19</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	7,297,155,470.56	9,624,983,633.19
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,550,424,843.48	7,781,365,167.07
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,480,077,355.57	6,518,231,622.00
Үндсэн цалин	3,003,209,386.57	3,443,020,565.00
Нэмэгдэл	1,983,255,288.00	2,451,666,633.00
Унаа хоолны хөнгөлөлт	77,380,000.00	249,796,300.00
Урамшуулал	288,768,298.00	243,708,200.00
Гэрээт ажлын хөлс	127,464,383.00	130,039,924.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,675,138.91	134,757,105.68
Тэтгэврийн даатгал	3,764,994.00	3,896,412.00
Тэтгэмжийн даатгал	442,939.00	231,004.00
ҮОМШӨ-ний даатгал	329,547.00	211,340.00
Ажилгүйдлийн даатгал	193,390.00	115,503.00
Эрүүл мэндийн даатгал	109,944,268.91	130,302,846.68
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,500,130.47	307,967,018.67
Гэрэл, цахилгаан	19,694,518.07	33,056,209.37
Түлш, халаалт	208,245,308.40	242,229,105.30
Цэвэр, бохир ус	25,560,304.00	32,681,704.00
Хангамж, бараа материалын зардал	199,063,284.74	239,246,288.99
Бичиг хэрэг	30,932,380.10	28,426,450.00
Тээвэр, шатахуун	126,954,531.68	165,826,523.99
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,625,772.96	9,040,538.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	1,800,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,450,600.00	9,682,100.00
Бараа материал акталсны зардал		24,470,677.00
Нормативт зардал	95,201,884.00	31,260,757.50
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,982,195.00	3,318,757.50
Хоол, хүнс	86,492,189.00	27,942,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,727,000.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	24,409,300.00	30,726,200.00
Багаж, техник, хэрэгсэл		2,489,900.00
Урсгал засвар	24,409,300.00	28,236,300.00
Томилолт, зочны зардал	27,907,400.00	44,683,500.00
Дотоод албан томилолт	27,907,400.00	44,683,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,128,893.00	7,522,889.51

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,099,720.00	4,660,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	782,100.00	2,470,412.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	397,500.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	
Газрын төлбөр	247,500.00	
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	282,073.00	392,477.51
Бараа үйлчилгээний бусад зардал	316,461,456.79	466,969,784.72
Бараа үйлчилгээний бусад зардал		12,457,884.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,185,655.23	35,795,200.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	312,275,801.56	418,716,700.72
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	746,730,627.08	1,843,618,466.12
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>721,966,742.00</b>	<b>1,587,370,644.00</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	103,446,602.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	356,752,686.00	985,516,722.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	238,162,453.00	464,834,320.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	125,551,603.00	33,573,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,763,885.08	256,247,822.12
Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	2,099,200.00	3,647,100.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	22,664,685.08	252,600,722.12
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III = I - II)</b>	<b>1,717,549,382.47</b>	<b>667,032,119.65</b>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	520,000.00	1,181,250.00
Үнэ төлбөргүй гарсан зардал-бараа материал	520,000.00	1,181,250.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI = IV - V)</b>	<b>-520,000.00</b>	<b>-1,181,250.00</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (VII = III + VI)</b>	<b>1,717,029,382.47</b>	<b>665,850,869.65</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,995,694,555.00	9,216,447,796.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	6,995,694,555.00	9,216,447,796.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	163,578,955.00	151,564,546.00
Нийтлэг татварын бус орлого	163,578,955.00	151,564,546.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	163,578,955.00	151,564,546.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,878,955.00	151,356,146.00
Ялын лавлагааны орлого		129,266,846.00
Журмын хашааны орлого		595,000.00
Шуудан тээврийн орлого		21,494,300.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,700,000.00	
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		208,400.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,832,115,600.00	9,064,883,250.00
Улсын төвлөрсөн төсвөөс	6,711,755,000.00	9,015,085,700.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,711,755,000.00	9,015,085,700.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	120,360,600.00	49,797,550.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,500,000.00	2,500,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,104,000.00	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,756,600.00	47,297,550.00
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>6,990,736,655.00</b>	<b>9,234,961,136.00</b>

УРСГАЛ ЗАРДАЛ	6,990,736,655.00	9,234,961,136.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,231,306,027.92	7,333,446,293.88
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,478,620,397.98	6,520,552,843.03
Үндсэн цалин	2,768,922,430.91	3,321,148,057.19
Нэмэгдэл	2,000,809,000.07	2,605,609,893.00
Унаа хоолны хөнгөлөлт	65,691,232.00	254,385,898.00
Урамшуулал	547,232,643.00	277,630,387.84
Гэрээт ажлын хөлс	95,965,092.00	61,778,607.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,675,138.91	134,906,007.68
Тэтгэврийн даатгал		3,896,412.00
Тэтгэмжийн даатгал		231,004.00
ҮОМШӨ-ний даатгал		211,340.00
Ажилгүйдлийн даатгал		115,503.00
Эрүүл мэндийн даатгал	114,675,138.91	130,451,748.68
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,500,130.47	307,967,018.67
Гэрэл, цахилгаан	19,694,518.07	33,056,209.37
Түлш, халаалт	208,245,308.40	242,229,105.30
Цэвэр, бохир ус	25,560,304.00	32,681,704.00
Хангамж, бараа материалын зардал	184,914,652.56	225,489,108.00
Бичиг хэрэг	23,147,600.00	27,374,600.00
Тээвэр, шатахуун	124,252,852.00	177,814,370.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,014,200.56	8,982,038.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	1,800,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,400,000.00	9,518,100.00
Нормативт зардал	78,526,175.00	28,302,002.50
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,799,375.00	360,002.50
Хоол, хүнс	75,226,800.00	27,942,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	32,490,797.00	31,002,700.00
Багаж, техник, хэрэгсэл	4,935,397.00	3,067,400.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,904,000.00	
Урсгал засвар	25,651,400.00	27,935,300.00
Томилолт, зочны зардал	28,954,600.00	44,683,500.00
Дотоод албан томилолт	28,954,600.00	44,683,500.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	55,450,236.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,613,436.00	3,252,664.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,160,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	871,800.00	92,664.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	397,500.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	
Газрын төлбөр	247,500.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	4,173,900.00	37,290,450.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,173,900.00	37,290,450.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>759,430,627.08</b>	<b>1,901,514,842.12</b>
Бусад урсгал шилжүүлэг	734,666,742.00	1,587,370,644.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	103,446,602.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	356,752,686.00	985,516,722.00

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	238,162,453.00	464,834,320.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	138,251,603.00	33,573,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,763,885.08	314,144,198.12
Төвлөрүүлэх шилжүүлэг	22,664,685.08	306,006,868.12
Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	2,099,200.00	8,137,330.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ( III = I -II)</b>	<b>4,957,900.00</b>	<b>-18,513,340.00</b>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	24,826,900.00	13,500,000.00
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>24,826,900.00</b>	<b>13,500,000.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,826,900.00	13,500,000.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-24,826,900.00</b>	<b>-13,500,000.00</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX =VII -VIII)</b>		
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-19,869,000.00</b>	<b>-32,013,340.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,882,340.00	32,013,340.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,013,340.00	

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Балансын үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
2024 ОНЫ 01 САРЫН 01-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	975,948,623.99	450,262,511.83	2,580,757,537.12	4,006,968,672.94
<b>ДАХИН ИЛЭРХИЙЛСЭН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>975,948,623.99</b>	<b>450,262,511.83</b>	<b>2,580,757,537.12</b>	<b>4,006,968,672.94</b>
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	109,830,000.00	0	1,717,029,982.47	1,826,859,982.47
<b>2024 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>1,085,778,623.99</b>	<b>450,626,511.83</b>	<b>4,297,787,519.59</b>	<b>5,833,828,655.41</b>
2024 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	1,085,778,623.99	450,262,511.83	4,297,787,519.59	5,833,828,655.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,307,597.90	1,307,597.90
<b>ДАХИН ИЛЭРХИЙЛСЭН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>1,085,778,623.99</b>	<b>450,262,511.83</b>	<b>4,299,095,117.49</b>	<b>5,835,136,253.31</b>
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	665,850,869.65	665,850,869.65
<b>2025 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>1,085,778,623.99</b>	<b>450,262,511.83</b>	<b>4,964,945,987.14</b>	<b>6,500,987,122.96</b>

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>9,113,085,700.00</b>	<b>8,860,484,977.88</b>	252,600,722.12	97.23
Улсын төсвөөс	9,113,085,700.00	8,860,484,977.88	252,600,722.12	97.23
Урсгал	9,113,085,700.00	8,860,484,977.88	252,600,722.12	97.23
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>9,113,085,700.00</b>	<b>8,860,484,977.88</b>	252,600,722.12	97.23
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>6,697,654,500.00</b>	<b>6,655,458,850.71</b>	42,195,649.29	99.37
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>6,552,812,500.00</b>	<b>6,520,552,843.03</b>	32,259,656.97	99.51
Цалин	3,297,634,400.00	3,321,148,057.19	(23,513,657.19)	100.71
Цалингийн тусгай нэмэгдлүүд	3,255,178,100.00	3,199,404,785.84	55,773,314.16	98.29
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>144,842,000.00</b>	<b>134,906,007.68</b>	9,935,992.32	93.14

Тэтгэврийн даатгал болон тэтгэмжийн шимтгэл	5,367,900.00	4,454,259.00	913,641.00	82.98
Эрүүл мэндийн даатгалын хураамж	139,474,100.00	130,451,748.68	9,022,351.32	93.53
<b>Бараа ,үйлчилгээний урсгал зардал</b>	<b>764,865,500.00</b>	<b>644,661,483.17</b>	120,204,016.83	84.28
Гэрэл, цахилгаан	33,417,500.00	33,056,209.37	361,290.63	98.92
Түлш, халаалт	245,970,200.00	242,229,105.30	3,741,094.70	98.48
Цэвэр, бохир ус	33,741,200.00	32,681,704.00	1,059,496.00	96.86
Хоол	29,893,900.00	26,342,000.00	3,551,900.00	88.12
Эм	747,400.00	360,002.50	387,397.50	48.17
Бичиг хэргийн материал	38,118,500.00	27,374,600.00	10,743,900.00	71.81
Тээвэр, шатахууны зардал	236,260,900.00	176,238,860.00	60,022,040.00	74.60
Шуудан холбооны зардал	11,511,600.00	8,982,038.00	2,529,562.00	78.03
Дотоод томилолтын зардал	65,446,600.00	44,683,500.00	20,763,100.00	68.27
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	19,935,900.00	7,410,000.00	12,525,900.00	37.17
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,725,800.00	2,982,664.00	2,743,136.00	52.09
Урсгал засварын зардал	28,615,500.00	27,935,300.00	680,200.00	97.62
Зөөлөн эдлэл, нормын хувцас,	2,987,400.00	-	2,987,400.00	-
Эд хогшил худалдан авах зардал	5,059,000.00	3,067,400.00	1,991,600.00	60.63
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	449,800.00	1,800,000.00	(1,350,200.00)	400.18
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,984,300.00	9,518,100.00	(2,533,800.00)	136.28
Бусад урсгал шилжүүлэг	<b>1,650,565,700.00</b>	<b>1,560,364,644.00</b>	90,201,056.00	94.54
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	103,446,700.00	103,446,602.00	98.00	100.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,002,984,400.00	985,516,722.00	17,467,678.00	98.26
Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	535,834,600.00	464,834,320.00	71,000,280.00	86.75
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,300,000.00	6,567,000.00	1,733,000.00	79.12
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>9,113,085,700.00</b>	<b>8,860,484,977.88</b>	252,600,722.12	97.23
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	32,013,340.00	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>46,150,450.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>46,150,450.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	46,150,450.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	900,000.00
Тээвэр, шатахуун	900,000.00
<b>Нормативт зардал</b>	1,600,000.00
Хоол, хүнс	1,600,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,500,000.00
Багаж, техник, хэрэгсэл	13,500,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	270,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	270,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,880,450.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,880,450.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	49,797,550.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	49,797,550.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	47,297,550.00

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 259,348.4 мянган төгрөгийн 6 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

### Залруулсан алдаа:

1. Санхүүгийн тайланд оны эхэнд бүртгэсэн Дотоодын цэргийн албан хаагчдад төлөх цалингийн өглөгийн 1,062.0 мянга, албан хаагч Түмэннасанд төлөх томилолтын өглөгийн 96.0 мянга, нийт 1,158.0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй;
2. Ахмадын сангаас ахмад настнуудад цагаан сарын урамшуулалд олгосон нэг ахмад настны нэр данс зөрүүтэйгээс байгууллагын дансанд буцаж орсон 158.4 мянга, аж ахуйн нэгжээс данс андуурч тушаасан тэмдэгтийн хураамжийн 50.0 мянга, нийт 208.4 мянган төгрөгийг тайлант үеийн орлогоор бүртгэсэн;
3. Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 149,5 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан;
4. Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй автомашинуудын тээврийн хэрэгслийн татварт 1,378.4 мянга, зам ашигласны төлбөрт 810,0 мянга, агаарын бохирдлын төлбөрт 189,3 мянга, нийт 2,377.7 мянган төгрөгийн өглөгийг болон орон нутгийн төсвөөс төрийн үйлчилгээний албан хаагчдын нэмэгдэлд 1,354.1 мянган төгрөгийг олгосныг албан хаагчдад олгоогүй атлаа санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй;
5. Байгууллагын дарга, "Цог энтертаймент медиа студи" ХХК-тай 2025.03.19-ний өдөр улирал тутамд 2 контент хийх ажлын гэрээг 3,000.0 мянган төгрөгөөр байгуулж, ажлыг дуусган хүлээн авсан ба тайлант онд 1,500.0 мянган төгрөгийг төлж, оны эцэст 1,500.0 мянган төгрөгийн өглөгтэй байхад санхүүгийн тайланд тусгаагүй
6. Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 252,600.7 мянган төгрөгийг хасаагүй буруу тайлагнасан.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн аудитын "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэл болон УСНББОУС-19 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, НББОУС-37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх стандартын заалт болон Үнэлгээ ба хуваарилалт, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 886,980.2 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 6,248.0 мянган төгрөгийн өртөг бүхий газрын асуудалтай холбоотой илэрсэн зөрчилд зөвлөмжийг өгч, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 880,732.2 мянган төгрөгийн мэдээллүүдийг байршуулаагүй зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 886,980.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдааны 880,732.2 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал тул материаллаг бусаар тооцсон, аудитаар илэрсэн 6,248.0 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### **5.1. Албан шаардлага**

1. Байгууллагын нягтлан бодогч шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2025 онд авсан 8,428,322.6 мянган төгрөгийн орлогын 33 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 805,908.8 мянган төгрөгийн 22 зарлагын гүйлгээ, байгууллагын даргын 66,323.4 мянган төгрөгийн 18 тушаал, тайлант онд төсвийн захирагчтай байгуулсан 8,500.0 мянган төгрөгийн 8 гэрээ, худалдан авах ажиллагааны тайлан, 10, 11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсвийн өөрчлөлтийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.3 дахь “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллүүдийг нөхөн байршуулах.

#### **5.1. Зөвлөмж**

1. Байгууллагын санхүүгийн тайланд 17 газар бүртгэлтэйгээс Галуут, Баян-Өндөр, Жинст сумдын газарт гэрчилгээ гараагүйгээс e-gazag цахимтай тулгах боломжгүй, нягтлан бодох бүртгэлд 6,248.0 мянган төгрөгийн үнэлгээ бүхий Конторын газар, Бөмбөгөр, Жаргалант, Баянцагаан, Жаргалант сумдын цагдаагийн кабоны газрын хэмжээ гэрчилгээний газраас зөрүүтэй бүртгэгдсэн зөрчилтэй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй 6,248.0 мянган төгрөгийн үнэлгээтэй газруудын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган зөрчлийг арилгах

**Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланд оны эхэнд бүртгэсэн Дотоодын цэргийн албан хаагчдад төлөх цалингийн өглөгийн 1,062.0 мянга, албан хаагч Түмэннасанд төлөх томилолтын өглөгийн 96.0 мянга, нийт 1,158.0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна.	1	1,158.0	1	1,158.0			1	1,158.0				
Ахмадын сангаас ахмад настан Д.Пүрэвдоржид цагаан сарын урамшуулалд олгосон зардал нэр данс зөрүүтэйгээс дансанд буцаж орсон 158.4 мянга, аж ахуйн нэгжээс данс андуурч тушаасан тэмдэгтийн хураамжийн 50.0 мянга, нийт 208.4 мянган төгрөгийг тайлант үеийн орлогоор бүртгэсэн байна.	1	208.4			1	208.4	1	208.4				
Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 149,5 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.	1	149.5			1	149.5	1	149.5				
Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй автомашинуудын тээврийн хэрэгслийн татварт 1,378.4 мянга, зам ашигласны төлбөрт 810,0 мянга, агаарын бохирдлын төлбөрт 189,3 мянга, нийт 2,377.7 мянган төгрөгийн өглөгийг болон орон нутгийн төсвөөс төрийн үйлчилгээний албан хаагчдын нэмэгдэлд 1,354.1 мянган төгрөгийг олгосныг албан хаагчдад олгоогүй атлаа санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.	1	3,731.8	1	3,731.8			1	3,731.8				
Байгууллагын дарга, "Цог энтертаймент медиа студи" ХХК-тай 2025.03.19-ний өдөр улирал тутамд 2 контент хийх ажлын гэрээг 3,000.0 мянган төгрөгөөр байгуулж, тайлант онд 1,500.0 мянган төгрөгийг төлж, оны эцэст 1,500.0 мянган төгрөгийн өглөгтэй байхад санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	1,500.0	1	1,500.0			1	1,500.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 252,600.7 мянган төгрөгийг хасаагүй буруу тайлагнасан.	1	252,600.7			1	252,660.7	1	252,660.7				
<b>ДҮН</b>	<b>6</b>	<b>259,348.40</b>	<b>3</b>	<b>6,389.75</b>	<b>3</b>	<b>253,018.65</b>	<b>6</b>	<b>259,408.40</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын санхүүгийн тайланд 17 газар бүртгэлтэйгээс Галуут, Баян-Өндөр, Жинст сумдын газарт гэрчилгээ гараагүйгээс e-gazag цахимтай тулгах боломжгүй, нягтлан бодох бүртгэсэн 17 газраас Конторын газар, Бөмбөгөр, Жаргалант, Баянцагаан, Жаргалант сумдын цагдаагийн кабоны газрын хэмжээ гэрчилгээний газраас зөрүүтэй бүртгэгдсэн байна.	1	6,248.0					1	6,248.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>6,248.0</b>					<b>1</b>	<b>6,248.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Байгууллагын нягтлан бодогч шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2025 онд авсан 8,428,322.6 мянган төгрөгийн орлогын 33 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 805,908.8 мянган төгрөгийн 22 зарлагын гүйлгээ, байгууллагын даргын 66,323.4 мянган төгрөгийн 18 тушаал, тайлант онд төсвийн захирагчтай байгуулсан 8,500.0 мянган төгрөгийн 8 гэрээ, худалдан авах ажиллагааны тайлан, 10, 11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсвийн өөрчлөлтийг байршуулаагүй байна.	1	880,732.2			1	880,732.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>880,732.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>880,732.2</b>	<b>0</b>	

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

---oOo---